



## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/437

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах  
түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.11, 19.18, 19.20, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг шинээр олгох, сунгах, түдгэлзүүлэх, шинжээч ажиллах байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, сунгасан байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (Л.Лхамсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийг сунгасан, олгосон байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТСАЙХАН

Захирамж 2019

811191377

аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын 26 өдрийн  
#437 дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгосон байгууллагууд

д/д	Байгууллагын нэр	Олгосон хугацаа	Дуусах хугацаа
1.	Тосонцэнгэл "Наран очир" хайрхан хувийн эмнэлэг	2019.12.03	2022.12.03
2.	Улиастай Ахуйн шавж, мэрэгч устгал. Ариутгал, халдваргүйтгэл үйлчилгээ эрхлэх "ЦЭ.СО.ББ" ХХК	2019.12.03	2022.12.03

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрлийг сунгасан байгууллагууд

д/д	Байгууллагын нэр	Сунгасан хугацаа	Дуусах хугацаа
1.	Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг	5 жил	2024.12.03
2.	Идэр сумын "Эмийн эргэлтийн сан"	5 жил	2024.12.03

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлсэн байгууллагууд

д/д	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах
1.	Тосонцэнгэл "Чацаргана" эмийн сан	2023.03.04
2.	Тосонцэнгэл "Вансэмбэрүү" эмийн сан	2023.01.26

Шинжээчдийн баг ажиллуулах саналтай төсөл

д/д	Төслийн нэр	Хариуцагч
1.	Улиастай "ХЕПАМЕД" хувийн эмнэлгийн төсөл	Их эмч Д.Жавзмаа

.....0.....